Цэнгэл сумын Засаг дарга нь эдийн засаг, нийгмийн асуудлаар бие даан шийдвэр гаргах, төрийн бодлого, хууль тогтоомжийн биелэлтийг хэрэгжүүлэх, иргэдэд үзүүлэх засаг захиргааны болон нийгмийн үйлчилгээг зохион байгуулах, хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм.

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Цэнгэл сумын Засаг дарга нь 2024 онд “Хүний нөөц, газар, байгалийн баялаг, мал аж ахуй, дэд бүтцийн давуу талдаа тулгуурласан бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан, үйлдвэр, аялал жуулчлал, нийгмийн үйлчилгээний харилцан бие биеэ нөхөх зөв зохистой бүтэц бүхий цогц салбаруудыг хөгжүүлж хүн амын амьдрах таатай орчныг бүрдүүлсэн сум болно.” зорилго дэвшүүлжээ.

Дээрх зорилгын хүрээнд доорх дэд зорилтуудыг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүнд:

- I. Уур амьсгалын өөрчлөлт, бэлчээрийн даацад нийцсэн мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлнэ.
- II. Хадлан бэлчээрийн нөөцийг сайжруулж, бэлчээр ашиглалтын хамтын менежментийг төлөвшүүлнэ.
- III. Сумын хүн амын төмс, хүнсний ногооны хэрэгцээг өөрийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хангана.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Цэнгэл сумын Засаг дарга нь Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь тус аймгийн төсөвт байгууллагуудын санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм. Тус албанаас тайлант онд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан бэлтгэхтэй холбоотой Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна.

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дугаар тушаалаар баталсан “Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна..

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 835.4 сая төгрөгөөр буюу 17.0 хувиар өссөн байна.

Хүснэгт №1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	174,996.65	378,863.65	203,867.00
Авлага	409,741.50	378,856.50	(30,885.00)
Урьдчилж гарсан зардал			-
Бараа материал	5,674.50	8,703.50	3,029.00
Нөөцийн бараа	62,446.00	20,000.00	(42,446.00)
Үндсэн хөрөнгө	4,276,104.41	4,977,956.42	701,852.01
Нийт хөрөнгө	4,928,963.06	5,764,380.08	835,417.01
Өр төлбөр	-	2,022.89	2,022.89
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	4,928,963.06	5,762,357.18	833,394.12
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,928,963.06	5,764,380.08	835,417.01

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Судалгаанаас харахад мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, нөөцийн бараа, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо дансдад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 378.8 сая төгрөг болж, оны эхнээс 203.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө	-	-	-
Банканд байгаа бэлэн мөнгө	174,996.65	378,863.65	203,867.00
Төгрөг	174,996.65	378,863.65	203,867.00
Төрийн сангийн харилцах	174,996.65	378,863.65	203,867.00
Дүн	174,996.65	378,863.65	203,867.00

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өссөн нь орон нутгийн ерөнхий орлогын данс, ОНХС, ХХС-гийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой байна. Орон нутгийн ерөнхий орлогын

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

данс 282.4 сая төгрөгийн, ОНХС-гийн данс 57.1 сая төгрөгийн, Хоршоо хөгжүүлэх сангийн данс 39.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- *ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар болон харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар мөнгөн хөрөнгө данстай холбоотой зөрчил гараагүй.*

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 378.9 сая төгрөг болж, оны эхнээс 30.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Зээлийн хүүгийн авлага	32,087.75	28,051.62	(4,036.13)
Байгууллагаас авах авлага			-
Хувь хүмүүсээс авах авлага			-
Зээлийн авлага	377,653.75	350,804.88	(26,848.87)
Хувь хүмүүст олгосон зээл	377,653.75	350,804.88	(26,848.87)
Дүн	409,741.50	378,856.50	(30,885.00)

Эх сурвалж: *Аудит хийсэн санхүүгийн тайлан*

Авлагын дансны үлдэгдэл буурсан нь сумын Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн авлага 4.0 сая төгрөгөөр, зээлийн хүүгийн авлага 26.8 сая төгрөгөөр буурсан байна. ХХС-гийн эргэн төлөлтөөс 89.0 сая төгрөгийн зээл олгосон байна.

Аудитын илрүүлэлт:

- *Хоршоо хөгжүүлэх сангаас 88.2 сая төгрөгийн зээлийн хариуцагч нь нас барсан, төлбөрийн чадваргүй гэх мэт шалтгаанаар төлөгдөх найдваргүй болж хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй байна.*

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилж гарсан зардал дансанд өөрчлөлт ороогүй байна.

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 8.7 сая төгрөг болж, оны эхнээс 3.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	-	-	-
Хангамжийн материал	5,674.50	8,703.50	3,029.00
Аж ахуйн материал	195.00	195.00	-
Бусад хангамжийн материал	5,479.50	8,508.50	3,029.00

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Мал амьтад			-
Дүн	5,674.50	8,703.50	3,029.00

Эх сурвалж: *Аудит хийсэн санхүүгийн тайлан*

Бараа материалын үлдэгдэл өссөн нь сумын ИТХ, ЗДТГ-ын бусад хангамжийн материалын эхний үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

Бараа материал данстай холбоотой зөрчил гараагүй.

3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө:

Нөөцийн бараа оны эхний 42.4 сая төгрөгийн тэжээлийг зарцуулж, оны эцэст сумын ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэсэн 20.0 сая төгрөгийн тэжээлийн нөөцийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 5. Бусад эргэлтийн хөрөнгийн буюу Нөөцийн бараа үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Нөөцийн бараа	62,446.00	20,000.00	(42,446.00)
Тэжээлийн нөөц	62,446.00	20,000.00	(42,446.00)
Дүн	62,446.00	20,000.00	(42,446.00)

Эх сурвалж: *Аудит хийсэн санхүүгийн тайлан*

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 4,978.0 сая төгрөг болж, оны эхнээс 701.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	4,113,121.17	4,814,591.08	701,469.91
Барилга, байгууламж, орон сууц	1,395,920.91	1,945,522.92	549,602.01
Авто-тээврийн хэрэгсэл	10,470.00	65,104.27	54,634.27
Машин тоног төхөөрөмж(компьютер)	1,514,927.40	1,523,509.30	8,581.91
Тавилга, аж ахуйн эд хогшил	16,453.33	26,280.72	9,827.39
Зам, гүүрийн байгууламж	1,004,276.40	1,053,870.96	49,594.55
Бусад үндсэн хөрөнгө	171,073.14	200,302.91	29,229.78
Биет бус хөрөнгө	162,983.24	163,365.35	382.11
Программ хангамж	1,423.24	1,805.35	382.11
Бусад биет бус хөрөнгө	161,560.00	161,560.00	-
Дүн	4,276,104.41	4,977,956.42	701,852.01

Эх сурвалж: *Аудит хийсэн санхүүгийн тайлан*

Үндсэн хөрөнгийн данс өссөн нь ЗДТГ-ын төсвийн хөрөнгөөр худалдан авсан хөрөнгө, аймаг, сумын ОНХС-гийн үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- *ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар үндсэн хөрөнгө данстай холбоотой зөрчил гараагүй.*

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3.5.7 Өр төлбөр

Өр төлбөрийн дансны үлдэгдэл 2.0 сая төгрөг болж шинээр нэмэгдсэн байна.

Хүснэгт 7. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

<i>/ мянган төгрөгөөр/</i>			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Өглөг	-	-	-
Бараа үйлчилгээний зардлын өглөг			-
Бусад өглөг	-	2,022.89	2,022.89
Байгууллагад төлөх өглөг	-	2,022.89	2,022.89
Хувь хүмүүст төлөх өглөг			
Дүн	-	2,022.89	2,022.89

Эх сурвалж: *Аудит хийсэн санхүүгийн тайлан*

Өр төлбөр данс оны эхний үлдэгдэлгүй, Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэг түлш халаалтын шинээр 2.0 сая төгрөгийн өглөгтэй гарсан байна.

Аудитын илрүүлэлт:

- *ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар өглөг данстай холбоотой зөрчил гараагүй.*

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо данс тайлант оны үр дүнгийн хэмжээгээр 833.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 8. Засгийн газрын хувь оролцоо

<i>/ сая төгрөгөөр/</i>			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	520,738.96	520,738.96	-
Хуримтлагдсан үр дүн	3,934,967.44	4,768,361.55	833,394.12
Өмнөх үеийн үр дүн	4,033,794.37	3,934,967.44	(98,826.93)
Тайлант үеийн үр дүн	(98,826.93)	833,394.12	932,221.05
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	473,256.67	473,256.67	-
Дүн	4,928,963.06	5,762,357.18	833,394.12

Эх сурвалж: *Аудит хийсэн санхүүгийн тайлан*

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Цэнгэл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрт зориулан нийтдээ 4,042.6 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 2,261.3 сая төгрөгийг урсгал зардалд, 933.0 сая төгрөгийг хөрөнгийн зардалд баталжээ.

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Нийт зардлын 502.1 сая төгрөгийг улсын төсвийн санхүүгийн дэмжлэгээр, 2,239.9 сая төгрөгийг сумын орон нутгийн төсвийн орлогоос, 924.5 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэхээр, 150.0 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэн, 226.1 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Цэнгэл сум нь 2024 онд гүйцэтгэлээр нийтдээ 3,248.0 сая төгрөгийн санхүүжилтийн орлого бүрдүүлснээс сумын орон нутгийн төсвөөс 2,234.2 сая төгрөгийн, Орон нутгийн хөгжлийн сангаас 886.6 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 127.2 сая төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлттэй холбоотой 641.4 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу авч, оны эцэст орон нутгийн төсвөөс авсан санхүүжилтээс 130.3 сая төгрөгийг төвлөрүүлж, үндсэн үйл ажиллагааны орлого /Хоршоо хөгжүүлэх сан/ 22.8 сая төгрөгөөр тасарсан үзүүлэлттэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,194.3 сая төгрөг буюу 79.0 хувьтай байгаа нь төвлөрүүлсэн болон дутуу авсан санхүүжилт, тасарсан орлого, эхний үлдэгдлээс зарцуулсантай холбоотой байна.

Сумын орон нутгийн төсвийн орлогын талаар:

Үндсэн үйл ажиллагааны орлогоос 127.2 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн нь Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс орсон орлого байна.

Аймгийн ИТХ-ын хуралдааны “2024 оны төсөвт тодотгол хийх тухай” 2024 оны 262 дугаар тодотголоор 1,734.8 сая төгрөгөөр тодотгож баталсан байна.

Сумын ИТХ-ын 2023 оны 20 дугаар тогтоолоор Цэнгэл сумын 2024 орлогын төлөвлөгөөг 1,542.6 сая төгрөгөөр баталж, сумын ИТХ-ын 2024 оны 11 дүгээр сарын 14-ны өдрийн 14 дугаар тогтоолоор 2024 орлогын төлөвлөгөөг анх баталснаас 581.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж 2,124.4 сая төгрөгөөр тодотгож баталсан байна.

Гүйцэтгэлээр сумын орон нутгийн төсвийн орлогод нийтдээ 1,874.2 сая төгрөгийн орлого оруулж, төлөвлөгөө 250.1 сая төгрөгөөр буюу 11.8 хувиар тасарсан байна.

Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын татварын орлогоос ХХОАТ-ын буцаан олголтод 72.5 сая төгрөг олгосон байна.

Хүснэгт 9. Орон нутгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
			Өсөлт/+/, бууралт /-/ хувь	Дүнд эзлэх хувь
I.Татварын орлого	2,081,102.20	1,802,317.66	(278,784.54)	86.6
II.Татварын бус орлого	43,250.00	71,907.17	28,657.17	166.3
Нийт дүн	2,124,352.20	1,874,224.83	(250,127.37)	88.2

Эх сурвалж: *Аудит хийсэн санхүүгийн тайлан*

Орон нутгийн орлого төлөвлөгөө тасрахад цалин хөлсний орлогоос 257.3 сая төгрөгөөр, хөрөнгийн орлого 61.7 сая төгрөгөөр, хөрөнгө борлуулсны орлогоос 0.4 сая төгрөгөөр, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 16.9 сая төгрөгөөр, хог хаягдлын үйлчилгээний хураамж 4.4 сая төгрөгөөр, ойн нөөц ашигласны төлбөр 8.3 сая төгрөгөөр, газрын төлбөрийн орлого 29.9 сая төгрөгөөр, Үл хөдлөх хөрөнгийн татвар 100 хувь тасарсан байна.

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Орлогын төлөвлөгөө үйл ажиллагааны орлогын татвар 50.0 сая сая төгрөгөөр, бууны албан татвар 0.09 сая төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамж 13.9 сая төгрөгөөр, ан амьтны нөөц ашигласны төлбөр 5.0 сая төгрөгөөр, Хүү, торгуулийн орлого 12.3 сая төгрөгөөр тус тус давж биелэгдэн, төлөвлөгдөөгүй малын тоо толгойн албан татвараас 34.0 сая төгрөгөөр, шүүхийн шийдвэрээр иргэний торгох ял авсны орлогоос 16.3 сая төгрөгийн орлого оруулсан нь орон нутгийн орлого бүрдүүлэхэд нөлөөлсөн байна.

Орон нутгийн ерөнхий орлогын 910 тоот дансанд оны эхэнд 132.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба Орон нутгийн орлогын 995 тоот дансаар 1,874.2 сая төгрөгийн татварын орлого оруулж, аймгаас 502.1 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч, орлого төвлөрүүлэлтээс 8.1 сая төгрөг орж нийт 2,384.4 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, 2,234.2 сая төгрөгийн төсвийг зарцуулж, оны эцэст орон нутгийн төсвийн ерөнхий орлогын 910 тоот дансанд 282.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт 10. Төсвийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэлтийн талаар:

/мянган төгрөгөөр/

Д/д	Байгууллагын нэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт
1	Сумын ИТХ	326,763.30	193,763.42	132,999.88
2	Сумын ЗДТГ	1,361,391.80	1,153,208.44	208,183.36
3	Ерөнхий боловсролын 1-р сургууль	297,141.00	243,728.60	53,412.40
4	Ерөнхий боловсролын 2-р сургууль	286,819.00	235,489.10	51,329.90
5	Ерөнхий боловсролын 3-р сургууль	28,510.00	24,337.00	4,173.00
6	Ерөнхий боловсролын 4-р сургууль	48,880.00	38,182.00	10,698.00
7	Хүүхдийн 1-р цэцэрлэг	32,951.70	32,898.70	53.00
8	Хүүхдийн 2-р цэцэрлэг	36,754.00	36,745.18	8.82
9	Хүүхдийн 3-р цэцэрлэг	28,531.20	28,488.70	42.50
10	Хүүхдийн 4-р цэцэрлэг	29,740.00	20,780.99	8,959.01
11	Соёлын төв	92,664.70	76,094.85	16,569.85
12	Эрүүл мэндийн төв	92,359.80	85,017.68	7,342.12
13	Орон нутгийн хөгжүүлэх сан	1,230,080.20	933,038.26	297,041.94
14	Хоршоо хөгжүүлэх сан	150,000.00	92,559.37	57,440.63
Нийт дүн		4,042,586.70	3,194,332.30	848,254.40

Эх сурвалж: *Аудит хийсэн санхүүгийн тайлан*

Хүснэгтээс үзэхэд сумын ИТХ, ЗДТГ, сумын төсөвт байгууллагуудыг орон нутгаас санхүүжих тогтмол зардлын төсвийн гүйцэтгэл төлөвлөснөөс бага гүйцэтгэлтэй гарсан нь төлөвлөлттэй холбоотой, ОНХС-гийн төсвийн гүйцэтгэл он дамжсан төсөл арга хэмжээний дутуу олгосон санхүүжилттэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс 11.0 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 17.1 сая төгрөгийн нийтдээ 28.1 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч, хангамж, бараа материалын зардалд 2.4 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 18.7 сая төгрөгийг зарцуулж, оны эцэст 7.0 сая төгрөгийн орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн гүйцэтгэл, орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2024 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Үүрийнтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн тайланг 2025 оны 2 дүгээр сарын 28-ны өдрийн 01/46 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 1,695.2 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 25.4 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх шатны материаллаг байдлыг Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,546.7 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 28.6 сая төгрөгөөр аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор сумын төсөв байгууллагууд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд үйл ажиллагаатай хамааралтай 2 шалгуурт алдаа, зөрчил илрээгүй байна.

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн Шилэн дансны мэдээллээс программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгахад бүрэн мэдээлсэн байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100 хувьтай байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчид завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны мэдээллээс программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгахад цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын ОНХС-гийн 557.5 сая төгрөгийн, ХХС-гийн 99.0 сая төгрөгийн 73 орлогын, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 714.4 сая төгрөгийн зарлагын 125 мөнгөн гүйлгээг шилэн дансанд мэдээлээгүй байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 50.0 хувьтай зөрчилд албан шаардлага өгөгдсөнийг зөрчлийг арилгаж ажилласан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1. Сумын ТТЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн алдаа зөрчлийн талаар

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн, 4 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 1 байгууллага, 2 сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан.

Ерөнхий боловсролын 1, 2, 3 дугаар сургууль, Загаст нуур багийн сургууль, хүүхдийн 1, 2, 3, 4 дүгээр цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төвийн орон нутгийн төсвөөс олгосон тогтмол зардлын санхүүжилтийг нэгтгэлд хамруулсан байна.

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Сумын ЗДТГ, Ерөнхий боловсролын 2,3,4 дүгээр сургууль, Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланд “өөрчлөлтгүй” дүгнэлт, Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн. Сумын ИТХ, Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сан, хүүхдийн 1, 2, 3, 4 дүгээр хүүхдийн цэцэрлэг, Соёлын төвийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулж үзсэн.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа Засаг даргын тамгын газар, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Орон нутгийн хөгжлийн сан, Хоршоо хөгжүүлэх сангийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 1,383.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч үүнээс 1,230.1 сая төгрөгийн алдааг залруулж, 4.9 сая төгрөгийн төлбөрийн 2 акт тогтоож, 60.0 сая төгрөгийн 1 албан шаардлага, 88.2 сая төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

Бусад байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийтдээ 8,271.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч үүнээс 6,248.8 сая төгрөгийн алдааг залруулж, 13.3 сая төгрөгийн төлбөрийн 3 акт тогтоож, 731.1 сая төгрөгийн 5 албан шаардлага, 1,278.1 сая төгрөгийн 15 зөвлөмж өгсөн байна.

Хүснэгт 11. Төсөвт байгууллагуудын санхүүгийн тайлангаас илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл хүснэгтээр харуулбал

/мянган төгрөгөөр/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс									
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	ИТХурал	1	958.2			1	958.2						
2	ЗДТГазар	1	3,922.2			1	3,922.2						
3	ОНХС	3	1,290,080.2	1	1,230,080.2			1	60,000.0	1			
4	ХХС	1	88,256.5								1	88,256.5	
Орон нутгийн байгууллагын дүн		6	1,383,217.1	1	1,230,080.2	2	4,880.4	1	60,000.0	2	88,256.5		
1	Цэнгэл ЕБ-ын 1-р сургууль	10	6,055,898.6	6	5,821,557.8	2	12,515.0	1	211,519.3	1	10,306.5		
2	Цэнгэл ЕБ-ын 2-р сургууль /Тува/	2	63,861.6	1	63,861.6	-	-	-	-	1	-		
3	Цэнгэл ЕБ-ын 3-р сургууль /Руханият/	3	7,975.0	1	7,975.0	-	-	-	-	2	-		
4	Цэнгэл сумын Загастнуур багийн ЕБСургууль	2	63,861.6	1	63,861.6	-	-	-	-	1	-		
5	Хүүхдийн 1-р цэцэрлэг	3	1,169,426.1	-	-	-	-	1	2,513.0	2	1,166,913.1		
6	Хүүхдийн 2-р цэцэрлэг	4	157,109.7	1	115,376.9	-	-	1	2,513.0	2	39,219.8		
7	Хүүхдийн 3-р цэцэрлэг	1	41,761.6	-	41,761.6	-	-	-	-	1	-		
8	Хүүхдийн 4-р цэцэрлэг	3	641,736.4	1	127,168.4	-	-	2	514,568.0	-	-		
9	Соёлын төв	3	48,054.3	1	7,252.8	-	-	-	-	2	40,801.5		
10	Эрүүл мэндийн төв	4	21,678.0	-	-	1	794.2	-	-	3	20,883.8		
Бусад байгууллагын дүн		35	8,271,362.9	12	6,248,815.7	3	13,309.2	5	731,113.3	15	1,278,124.7		
Нийт дүн		41	9,654,580.0	13	7,478,895.9	5	18,189.6	6	791,113.3	17	1,366,381.2		

5.2. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар залруулга хийгдээгүй, зөрчил илрээгүй.

Аудитын дүнгээр Сумын Засаг дарга, Санхүүгийн албад дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

1. Сумын төсөвт байгууллагуудын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчилд өгсөн 18.2 сая төгрөгийн төлбөрийн 5 актыг хугацаанд нь

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

барагдуулах, 791.1 сая төгрөгийн 6 албан шаардлага, 1,366.4 сая төгрөгийн 17 зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж, үр дүнг тайлагнаж ажиллах;

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ТТЗ-ийн харьяа байгууллагуудад өгсөн аудитын шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тайлагнаагүй.	1						1					
Дүн	1						1					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит